



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 4/67

Алтанбулаг

Шалгарсан төсөлд зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолын хавсралт, сумын ИТХ-ын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 15 тоот, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 14 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гаргасан 2021 оны 03 дугаар сарын 22, 23-ны 01, 02 дугаар хурлын тэмдэглэл, шийдвэрийн дагуу Сум хөгжүүлэх сангаас олгох 20,000,000 /хорин сая/ төгрөгийг "Халуун усны газар барих" төсөл хэрэгжүүлэгч Чойдогжамц овогтой Сэргэлэнд олгосугай.

2.Батлагдсан төслийг журамд заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлж, зээлийн гэрээ хийж гүйцэтгэхийг Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн /Б.Одмаа/, Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Цэнд-Аюуш/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



НОТГОНЦОГТ